# СУРГАЛТЫН ТӨВИЙН БАГШ-ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ОЧИРДАНЗАНГИЙН ОТГОНГЭРЭЛИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## . Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бодлогын баримт бичиг болон үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжид тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргаж, хугацаанд нь тайлагнана. | 1. Харьяа гаалийн газар, хороодын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалд тавигдах шаардлагад саналаа тусгаж Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.<br>2. Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд найрамдах Узбекстан Улсын Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийн зүйл III хамтран ажиллах, харилцан туслах арга хэмжээний 2f, g, h хэсгийн хамрах хүрээнд санал боловсруулж Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлж ажилласан.<br>3. ГЕГ МУИС-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх ойрын, дунд, урт хугацааны төлөвлөгөөнд тусгах саналыг ГУБ багш С.Ариунаа, ГУБ багш Г.Баярмаа нарын хамт боловсруулж хүргүүлсэн. | 01.01-12.31 | 100 |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| | Сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлон, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. ГЕГ-ын ЗББНДБ, харъяа гаалийн газар, хороодын 2024 оны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа авч нэгтгэж, ГЕГ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулах | 1. Гаалийн байгууллагын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалтуудад өөрийн заадаг хичээлийн чиглэлээр лекц, PPT, слайд, үзүүлэн тараах материал, тест, кейс бэлдэн сургалтын үйл ажиллагаанд оролцсон. Үүнд:<br>2. Гаалийн байгууллагын 2024 оны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа авахад оролцсон. | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| боловсруулан хэрэгжүүлэх | | | | 3. “ГУБ-ийн ёс зүй” , “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа”, “CITES”-тай холбоотой зөрчил, “Мөнгө угаах гэмт хэрэг” хичээлийн хөтөлбөрийг хичээлийн агуулга, хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, дадал, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, хичээлийн үнэлгээ, хичээлд ашиглах ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг багтаан боловсруулж сургалтанд ашигласан.<br>4. Сургалтын төвийн 2024 оны төлөвлөгөө гаргахад оролцсон.<br>5. ГЕГ МУИС-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх ойрын, дунд, урт хугацааны төлөвлөгөөнд тусгах саналыг ГУБ багш С.Ариунаа, ГУБ багш Г.Баярмаа нарын хамт боловсруулж хүргүүлсэн.<br>6. ГЕГ-ын дэргэдэх олон нийттэй харилцах албатай сургалтын төв хамтран ажиллах тухай E-Learning платформд санал боловсруулж хүргүүлсэн. | | |
| Албан хаагчдыг чадавхжуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт 2 удаа /80 суралцагч/,<br>2. ГУБ нарын мэргэшүүлэх сургалт 6 удаа /150 ГУБ/,<br>3. Хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг чадавжуулах сургалт-2 удаа /80 ГУБ/<br>4. ДГБ-ын сургалтын хөтөлбөрийн хүрээнд гаальчдыг зайнаас сургах ажлыг зохион байгуулж, тайлагнах<br>5.Сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, зохион байгуулсан сургалтын тайланг нэгтгэн, үр дүн тооцсон байна. | Тайлант хугацаанд Гаалийн байгууллагын хүний нөөц, боловсон хүчнийг хангах, алба хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын хүрээнд гаалийн байгууллагад сонгон шалгаруулалтад тэнцэж шинээр орж ирсэн иргэдийг гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг Сургалтын төвөөс амжилттай зохион байгуулсан. Үүнд:<br>2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлсэн гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад нийт 32 цаг зааж 42 суралцагч, 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс эхэлсэн Замын-үүд дэх гаалийн газар/50/, Сайншанд дахь гаалийн газар/23/-ын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг мэргэшүүлэх “Өмнөд” бүсчилсэн сургалтаар 73 албан хаагчид 8 цагийн хичээл, 4 дүгээр сарын 29-ний өдрөөс эхэлсэн гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад нийт 40 цаг зааж 52 суралцагч, 7 дугаар сарын 22-ноос эхэлсэн гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад нийт 18 цаг зааж 40 суралцагч, 2024 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс эхэлсэн СЭГГ, ОРГГ, ДАГГ-ын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг мэргэшүүлэх “Хойд” бүсчилсэн сургалтаар 36 албан хаагчид 4 цагийн хичээл, 2024 оны 10 дугаар сарын | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 14-нд Баруун бүсийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж сургалтад Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Говь-Алтай дахь гаалийн хороо, Завхан аймаг дахь гаалийн хороо, Увс аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Хөвсгөл дэх гаалийн хороодын нийт 25 алба хаагчдад, 11 дүгээр сарын 18-наас эхэлсэн гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад нийт 16 цаг зааж 47 суралцагч хамрагдсан. 2024 оны 1 дүгээр сарын 19 нд ГЕГ-ын харьяа газар, хороодын удирдах албан тушаалтнуудад зориулсан "ГУБ нарт зориулсан VR технологид суурилсан L-THURSDAY 1.0" сургалт болон танилцуулгыг ГУБ багш Г.Тамирын хамт зохион байгуулсан. Мөн 2 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Дархан-уул аймаг дахь гаалийн газар, Орхон дахь гаалийн газрын 21 албан хаагчдад 4 цагийн хичээл, 3 дугаар сарын 28-ны өдөр Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газар, Шивээ хүрэн дэх гаалийн газрын нийт 22 албан хаагчдад ГУБ-ийн ёс зүй, сахилга, хариуцлагын чиглэлээр 4 цагийн лекц болон кэйсүүд дээр ярилцаж багаар ажиллуулсан. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу "ГУБ-ийн ёс зүй", "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" ,"VR сургалт", "CITES"-болон тэдгээртэй холбоотой зөрчил, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэг"-ийн тухай хичээлийг заасан.<br>Тайлант хугацаанд Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад нийт 32 цаг зааж 52 суралцагч хамрагдсан, "ГУБ-ийн ёс зүй", "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" ," CITES"-тай холбоотой зөрчил, "Мөнгө угаах гэмт хэрэг"-ийн тухай хичээлийг тус тус батлагдсан хуваарийн дагуу заасан. | | |
| Гааль судлалын хүрээнд хийгдсэн ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.МУИС-ийн багш нартай хамтран гаалийн байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлаар өгүүлэл, нийтлэл, судалгаа, бүтээл гарган, асуудлыг шийдэх боломжийн талаар санал боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангана. | "Гааль" сэтгүүлийн редакцийн зөвлөл байгуулах тухай ГЕГ-ын даргын тушаалын төслийг боловсруулж батлуулсан.<br><br>Сургалтын төв нь МУИС-ийн багш нартай хамтран, сэтгүүлээр дамжуулан гаалийн байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлаар өгүүлэл, нийтлэл, судалгаа, бүтээл гарган, асуудлыг шийдэх боломжийн талаар санал боловсруулж, удирдлагыг мэдээллээр ханган ажиллах юм. | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.Гааль судлалын нэгдсэн санг гаалийн харилцаанд оролцогчдод нээлттэй болгоно.<br>3. 4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | Сургалтын төвийн ГУАБ багш Л.Олонбаяр судалгааны ажлын хүрээнд МУИС-ын багш Н. Отгонсайхан профессорын нэрэмжит 2024 оны 04 дүгээр сарын 19-нд явагдсан хэлэлцүүлэгт “ Цаасгүй худалдааны хэлэлцээрээр дамжуулан худалдааг хөнгөвчлөх нь” сэдвээр илтгэлд багш нарын хамт оролцсон. Сургалтын төв нь ГЕГ, МУИС-ийн хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд Монгол Улсад худалдааны салбарын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жил, Гаалийн байгууллага үүсэж, хөгжсөний 112 жил, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тохиолдуулан “ГЛОБАЛ БИЗНЕС ДЭХ ШИНЭ ХАНДЛАГА” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-тай хамтран 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус хуралд худалдаа, гааль, глобал бизнесийн шинэ хандлагын талаар нийт 100 гаруй олон улсын болон дотоодын эрдэмтэн, судлаач, экспертүүд болон гаалийн байгууллагын албан хаагч, бусад байгууллагын төлөөлөл илтгэлүүдээ хэлэлцүүлэхэд багш нарын хамт оролцсон. Уг хуралд Сургалтын төвийн ГУАБ багш Л.Олонбаяр “Цаасгүй худалдааг хэрэгжүүлж буй зарим орны туршлага. Монгол Улсын авах сургамж” сэдвээр илтгэл тавьж , хэлэлцүүлсэн. | | |
| | Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалт 1 удаа зохион байгуулж, 100 хүний сургаж, сургалтын чанарыг захиалга өгсөн гаалийн зуучлагч байгууллагын сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тайлагнана.<br><br>2. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх сунгах шатны сургалт 1 удаа зохион байгуулж, 120 хүний сургаж, сургалтын чанарыг захиалга өгсөн гаалийн зуучлагч байгууллагын сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тайлагнана. | 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны мэдлэг олгох сургалт эхэлж батлагдсан хөтөлбөрийн дагуу Ёс зүй, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хичээлийг нийт 12 цагийн хичээл зааж 102 хүн хамрагдсан.<br>2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлсэн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтын хөтөлбөрийн дагуу Ёс зүй, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хичээлийг нийт 4 цагийн хичээл зааж 81 хүн хамрагдсан.<br>2024 оны 4 дүгээр 15-ны өдрөөс эхэлсэн “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт”-д 32 хүнд “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” ,”Ёс зүй” хичээлээр 8 цагийн лекц орсон.<br>2024 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлсэн “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэний мэдлэг олгох давтан сургалт”-аар 33 хүнд “Зөрчил галган шийдвэрлэх ажиллагаа”, “Ёс зүй” хичээлээр 4 цагийн хичээл заасан.<br>2024 оны 6 дугаар сарын 10-20-ны хооронд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дэлхийн Байгаль хамгаалах сан –ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулсан Монгол улсын баруун бүсийн хилийн 5 боомт дээр үүрэг гүйцэтгэж | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгаа хил хяналтын байгууллагуудын албан хаагчдад "Зэрлэг амьтны эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах нь" сэдэвт хөдөлгөөнт сургалтад гаалийн байгууллагыг төлөөлж сургалтаар "Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн холбогдох хэм хэмжээг зөрчих, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлог/ зүйлчлэл, харьяалал г.м/, бодит жишээ сэдвээр хичээл заасан. Сургалтад баруун бүсийн 5 аймгийн хил, гаалийн нийт 128 албан хаагчид хамрагдсанаас хилийн боомт дахь гаалийн байгууллагын төлөөлөл нийт 64 гаалийн улсын байцаагч хамрагдсан.<br>ДХИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд IV дамжааны эрх зүйн ангийн 25 суралцагчдад Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хичээлийг заасан.<br>ГЕГ-ын ёс зүйн дэд хороо, Хуулийн хэлтэс, Сургалтын төвийн хамтран зорион байгуулсан Ёс зүй, авлигын чиглэлээр Дэлхийн Гаалийн байгууллагын чиг хандлагыг үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй харьцуулан, өнөөгийн практикт хэрхэн хэрэгжүүлэх онол, практикийн мэдлэг эзэмшүүлэх сургалтыг Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дахь гаалийн газарт 2 удаагийн оролтоор 137 алба хаагчдад, цахим хэлбэрээр Дархан-уул аймаг дахь гаалийн газар, Шивээ хүрэн дэх гаалийн газар, Завхан дахь гаалийн хороо, Увс дахь гаалийн газрын 35 алба хаагчдад явуулсан. | | |
| Багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн багшлах эрхийн сургалтад 2 багшийг хамруулна. | Өөрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн гаалийн байгууллагын сургалтын цахим модулиудыг судалж мэдлэгээ дээшлүүлэх, үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлсэн https://clikc.wcoomd.org сайтаас өөрийн сонирхсон хичээлүүдийг үзэж "Ёс зүй", "Гаалийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" хичээлтэй танилцан сургалтын хөтөлбөртөө тусгаж ашигласан.<br>Олон улсын валютын сангаас зохион байгуулсан "Мөнгө угаахтай тэмцэх мөрдөн шалгалт хийх арга техник семинар 3 өдрийн сургалтад хамрагдсан.<br>Өөрсдийн багшлах ур чадвараа дээшлүүлэх зорилгоор МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн "Багшлах мэргэжил олгох" сертификатын 12 кредит агуулга бүхий сургалтад хамрагдаж амжилттай төгссөн. | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Удирдлагын академи дээр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэгт оролцсон.<br>ОУВС, ТЕГ-ын хамтран зохион байгуулсан " Мөнгө угаахтай тэмцэх болон татварын албадыг хоорондын мэдээллийн солилцоо, зохицуулалтыг сайжруулах-Техникийн туслалцаа үзүүлэх" ажлын хэсгийн 3 өдрийн сургалтад оролцсон.<br>ГЕГ-ын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс зохион байгуулсан 1 өдрийн сургалтад хамрагдсан.<br>Академик англи хэлний багш, дасгалжуулагч Г.Гэрэлтуяа багшийн 1 өдрийн хичээлд бэлдэх, агуулга, арга зүйд суралцахуй сургалтад хамрагдсан. | | |
| | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнана. | Сургалтын төв нь 2024 оны үйл ажиллагаандаа хууль тогтоомж, гаалийн байгууллагын журам, дүрэм, бусад эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласнаас гадна ГЕГ-ын нэгжүүдээс ирүүлсэн дараах эрх зүйн актын төсөлд саналаа цаг хугацаанд нь дотоод зурвасаар хүргүүлж байсан болно.<br>1. "ГУБ-ийн үйлчилгээний стандарт журам"-ын төсөл<br>2. "ГУБ-ийн сахилгын дүрэм"-ийн төсөл<br>3. "ГУБ-ийн ёс зүйн дүрэм"-ийн төсөл<br>4. "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын төсөл<br>5. "Албан тушаалын тодорхойлолт"-ын төсөл<br>6. 2024 онд гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал<br>7. "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн төсөл<br>8. "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын төсөл<br>9. ."Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн төсөл<br>10. "Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам"-ын төсөл<br>11. "Гаалийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" -ийн төсөл-д | 01.01-12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн батлагдсан бусад хууль тогтоомжид нийцүүлэн дүн шинжилгээ хийж нэмэлт, өөрчлөлт оруулах санал авч байгаатай уялдуулан холбогдох нэгжүүдэд дүрэм, журмуудад өөрчлөлт оруулах саналаа тусгаж хүргүүлсэн. | | |
| Үүрэг даалгаварын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Өгөгдсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. | ГЕГ-ын болон тус төвийн даргын өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлэн гүйцэтгэлийг тайлагнан ажилласан. Тухайлбал: Багш нарын хамт сургалтын төвийн сургалтын төлөвлөгөө болон бодлогын баримт бичгүүдийн төсөл, гааль судлалыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний хуралд бэлдэх бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх ажлууд, дүрэм, журамд оруулах санал, төлөвлөгөөт сургалтуудтай холбоотой цаг үеийн төлөвлөлт, мэдээ мэдээлэл, бусад нэгжүүд болон гаалийн газар хороодтой хамтарсан хөтөлбөр сургалтууд г.м. Тээврийн прокурорын газрын 2024 оны 05 дугаартай шаардлагын дагуу Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал дахь гаалийн газраас ирүүлсэн албан бичиг, ГЕГ-ын Хуулийн хэлтсийн 01-1.2/3711 дугаартай тус тус албан бичгийн хүрээнд ЗШША практик сургалтыг зохион байгуулсан. | 01.01-12.31 | 100 |
| Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 2023 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажилласан. | Хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж удирдлагаар баталгаажуулсан.<br>2024 онд АТГ-аас "Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл" сэдвээр нийт 4 удаагийн 8 цаг , багш -ГУБ О.Отгонгэрэл "ГУБ-ийн ёс зүй, сахилга хариуцлага ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалтын хөтөлбөрийн дагуу 18 цаг, нийт 40 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 616 суралцагч /АТГ -н сургалтад -207/ хамрагдсан байна. | 01.01-12.31 | 100 |
| Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна. | Тайлант хугацаанд ирц бүрэн ажилласан. Сургалтын ачаалал, давтамжаас хамаарч зарим багш нарын хамтаар хичээлийн бэлтгэл хангах, цаг үеийн үүрэг даалгавартай холбоотойгоор илүү цагаар ажилласан. | 01.01-12.31 | 100 |
| Үндсэн шалгуурт тусгагдаагүй | | | 1. ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа | ГЕГ-ын ЗУГ- аас зохион байгуулдаг баасан гаригийн "Мэдээллийн цаг" арга хэмжээнд бүрэн хамрагдаж байсан. Энэхүү "Мэдээллийн цаг" арга хэмжээнд төвийн зүгээс 2024 | 01.01-12.31 | 100 |

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ОЧИРДАНЗАНГИЙН ОТГОНГЭРЭЛИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Сургалтын төв

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | 55 | 8 | 63 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлон, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх | 55 | 8 | 63 | |
| 2 | Албан хаагчдыг чадавхжуулах | 55 | 9 | 64 | |
| 3 | Гааль судлалын хүрээнд хийгдсэн ажил | 53 | 10 | 63 | |
| 4 | Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 5 | Багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах | 60 | 10 | 70 | |
| 6 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 55 | 8 | 63 | |
| 7 | Үүрэг даалгаварын биелэлт | 57 | 9 | 66 | |
| 8 | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 54 | 9 | 63 | |
| 9 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 59 | 10 | 69 | |
| **Дундаж оноо:** | | | | 65.0 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | 100 | 14 | |
| 2 | МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн багшлах эрхийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. | 100 | 14 | |
| | **Дундаж оноо:** | | 14 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6.5 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6.0 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6.0 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6.5 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6.5 | |
| | **Дундаж оноо:** | **6.3** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо: 8** | |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *65.0* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *14.0* |

40

| | | |
|---|---|---|
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6.3** |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | *8.0* |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | - |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **92** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Сургалтын төвийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .................................. (Ч.Мөнххишиг)

*2024.12.10 (огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (О.Отгонгэрэл)

*2024.12.10 (огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг тэргүүлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

12/20, 2024 ........................ *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2024.12.20 ..................... *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

..................................*(огноо)*